



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 820

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9 нэрийн, нийт 355,172,841.28 (гурван зуун тавин таван сая нэг зуун далан хоёр мянга найман зуун дөчин нэгэн төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007463
37-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Исузу трүүлэр /Isuzu Trooper/, улсын дугаар 57-44 ГСА, суудлын, арлын дугаар JACUBS55N17103029	2001	ш	1	14,909,100.00	14,909,100.00	2,000,000.00
2	Тоёота Ланд крүйзер-105 /Toyota Land Cruiser-105/, улсын дугаар 44-55 ХЭУ, суудлын, арлын дугаар JTECJ09J605510731	2005	ш	1	115,674,400.00	115,674,400.00	8,000,000.00
3	Фургон УАЗ-220692-033, улсын дугаар 74-47 ХЭА, суудлын, арлын дугаар 374100B0447842	2011	ш	1	20,612,699.10	20,612,699.10	2,000,000.00
4	Ниссан Патрол /Nissan patrol/, улсын дугаар 26-51 ХЭН, суудлын, арлын дугаар JN1TFSY61Z0556048	2006	ш	1	80,072,096.73	80,072,096.73	10,000,000.00
5	УАЗ-469 чиргүүл	1995	ш	1	500,000.00	500,000.00	200,000.00
6	Киа лотзе /KIA LOTZE/, улсын дугаар 47-85 БРА, суудлын, арлын дугаар KNAGE22526A053393	2006	ш	1	14,000,000.00	14,000,000.00	1,500,000.00

7	УАЗ пургон 220692, улсын дугаар 43-49 ГСА, арлын дугаар 374100B0447829	2011	ш	1	27,704,545.45	27,704,545.45	2,000,000.00
8	Тоёота Ланд Крузер -100 /Toyota land cruiser-100/, улсын дугаар 00-20 ГСА, суудлын, арлын дугаар JTENT05J322021746	2002	ш	1	47,800,000.00	47,800,000.00	5,000,000.00
9	Дунд гарын жип Пик ап /Great Wall, CC1031PD6A/, улсын дугаар 57-05 ГСА, ачааны, арлын дугаар LGWCA2173DB000948	2013	ш	1	33,900,000.00	33,900,000.00	2,000,000.00
Нийт дүн					355,172,841.28	355,172,841.28	32,700,000.00
					(гурван зуун тавин сая нэг зуун далан хоёр мянга найман зуун дөчин нэгэн төгрөг хорин найман мөнгө)		
					(дүчин хоёр сая долоон зуун мянга)		